

ФИНЛАНД УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСЛҮҮДИЙН ОНЦЛОГ

1. Финландын их сургууль

Финландын дээд боловсролын байгууллагыг их сургууль, политехникийн дээд сургууль¹⁶ гэж хоёр үндсэн хэв шинжид ангилдаг. Их сургууль нь шинжлэх ухааны судалгаанд суурилдаг бол политехникийн дээд сургуулиуд нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх бөгөөд орон нутгийн түвшний судалгаа явуулдаг байна. Өмнө нь мэргэжлийн боловсролыг мэргэжлийн коллеж¹⁷-ууд олгодог байжээ. Харин 1991 оноос политехникийн дээд сургуулиуд шинээр туршилтаар байгуулагдаж, 1996 оноос үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэн байдаг. Политехникийн дээд сургууль нь мэргэжлийн зах зээл, орон нутгийн эдийн засагтай зайлшгүй нягт холбоотой. Их сургууль, политехникийн дээд сургуулийн төсөв нь засгийн газар болон орон нутгийн дэмжлэгээс бүрддэг. Үүний зэрэгцээ төсөл, судалгааны санхүүжилтийг Засгийн газраас тусгай журмын дагуу олгодог байна.

2. Финландын их сургуулийн санхүүжилтийн төрлүүд

а. Үндсэн санхүүжилт

Гол санхүүжилт нь их сургуулийн үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг юм. Дээд боловсрол үнэ төлбөргүй тул бүхий л үйл ажиллагааны зардлыг төрөөс санхүүжүүлдэг болно.¹⁸

б. Төсөл, судалгааны санхүүжилт

Төсөл, судалгааны санхүүжилт нь тусгай төсөл, судалгааг хэрэгжүүлэхэд зориулж их сургуульд олгодог санхүүжилт бөгөөд дийлэнх нь судалгааны санхүүжилт байдаг¹⁹.

Хүснэгт 1

Финландын дээд боловсролыг дэмжих төслийн төрлүүд

Төрөл	Төсөл		Тайлбар
Үндсэн санхүүжилт	Их сургуулийн үндсэн үйл ажиллагааны зардал		Төгсөгчдийн тоо, бүртгэлтэй оюутны тоонд тулгуурладаг.
Төсөл, судалгааны санхүүжилт	Үр дүнд суурилсан санхүүжилт	Их сургуулийн сургалтын тэргүүний төвийг дэмжих ²⁰	Сургалтыг дэмжих төсөл
		Судалгааны тэргүүний төвүүдийг дэмжих ²¹	Судалгаа дэмжих төсөл
	Төсөлд суурилсан судалгааны санхүүжилт	Био шинжлэх ухаан, хүрээлэн буй орчны судалгааны төсөл	
		Соёл, нийгэм судлалын төсөл	
		Байгалийн ухаан, инженерийн судалгааны төсөл	
	Эрүүл мэндийн судалгааны төсөл		

в. 'Их сургуулийн сургалтын тэргүүний төв'-ийг дэмжих төсөл (CEUE)

Финланд улс 1990-ээд оноос эхлэн их сургуулийн сургалт²²-ын чанарыг сайжруулах зорилго дэвшүүлэн, үүний хүрээнд их сургуулийн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлж ирсэн²³. Магадлан итгэмжлэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг дээд боловсролын сургалтын үйл ажиллагаанд оролцож буй бүхий л субъектүүдийн оролцоотойгоор боловсруулсан байна. Үүнд их сургууль, бизнес, үйлдвэрлэлийн байгууллага, судалгааны байгууллага, оюутан, боловсролын үнэлгээний мэргэжилтнүүд багтсан болно²⁴.

Мөн дээрх зорилгын хүрээнд Финландын Боловсролын яам 1998-2012 оны хугацаанд их сургуулийн сургалтыг дэмжих 'Их сургуулийн сургалтын тэргүүний төв'-үүдийг дэмжих санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлсэн байна.

¹⁶ polytechnics

¹⁷ college of vocation

¹⁸ Finnish Ministry of Education and Culture, 2014.

¹⁹ Academy of Finland, 2013; Finnish Higher Education Evaluation Council, 2009. Katainen-ийн засгийн газар буюу 2014 оноос эхлэн Finnish Education Evaluation Council, National Board of Education, Finnish Higher Education Evaluation Council гурван байгууллаган нэгдэн Education Evaluation Centre болж өөрчлөгдсөн.

²⁰ Centres of Excellence in University Education

²¹ Centres of Excellence in Research

Энэ төслийн зорилго нь их сургуулиудын тодорхой нэг бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүд сургалтын чанараа сайжруулахад дэмжлэг үзүүлэн, улмаар их сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах байв.

Мөн их сургуулийн сургалтын чухал болохыг мэдрүүлэх юм. Энэхүү төсөл нь 15 жилийн хугацаанд амжилттай хэрэгжиж, их сургуулиудад олон тооны хөгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж чадсан юм. Финланд улсын энэхүү бодлого Норвеги улсын дээд боловсролын сургалтын чанарыг сайжруулах бодлогод бенчмаркинг болсон²⁵.

Энэхүү төслийн шалгаруулалтыг Финландын Дээд боловсролын үнэлгээний зөвлөл (цаашид FINHEEC²⁶) гурван жилийн үечлэлээр хийдэг байжээ. Шалгаруулалтад их сургуулийг төлөөлж зөвхөн бүрэлдэхүүн сургууль, тэнхим оролцохыг зөвшөөрдөг бөгөөд их сургууль дангаараа оролцохыг зөвшөөрдөггүй.

Энэ нь шинжлэх ухааны чиглэлүүдийн онцлогийг харгалзан үзэх зорилготой ажээ. Шалгарсан бүрэлдэхүүн сургууль, тэнхимд гурван жилийн хугацаанд төслийн санхүүжилт олгодог байна.

Финландын Дээд боловсролын үнэлгээний хороо Их сургуулийн сургалтын тэргүүний төв төслийг зарлан сургалтын чанараараа тэргүүний нэгж буй их сургуулийн бүрэлдэхүүн сургууль, тэнхимийг шалгаруулан итгэмжлэн, Засгийн газар итгэмжлэлийн хугацаанд нэмэлт санхүүжилт олгодог. Санхүүжилтийн хэмжээ нь сургуулийн хэмжээнээс хамаарч ялгаатай байдаг. Шалгарсан сургуулиуд тухайн төсвийг хэрхэн хуваарилах, юунд зарцуулах нь чөлөөтэй (хараат бус) байдаг²⁷.

3. 'Их сургуулийн сургалтын тэргүүний төв' төслийн онцлог

а. Төслийн шалгаруулалт

FINHEEC шалгаруулалтын ажлын хэсэг байгуулж, ажлын хэсэг үнэлгээний шалгуур үзүүлэлт, үнэлгээний агуулга, үнэлгээний журам, хугацаа зэргийг боловсруулан FINHEEC-д танилцуулдаг. 2010-2012 оны төслийн үнэлгээний шатлал нь дараах 5 шаттай байсан. Үүнд:

- FINHEEC үнэлгээний журам, төслийн зар
- Их сургуулиуд төсөлд шалгаруулалтын материалаа өгнө

- Олон улсын мэргэжилтнүүд материалтай танилцан, нэгж дээр очиж танилцах байгууллагуудыг сонгоно.

Олон улсын мэргэжилтэн, дотоодын мэргэжилтнүүд нэгж дээр очиж шалгана Үнэлгээний ажлын хэсэг Их сургуулийн сургалтын тэргүүний төвийг дэмжих төсөлд шалгаруулан FINHEEC-д хүргүүлнэ.

- FINHEEC үнэлгээний үр дүнг хянан үзэж эцсийн шалгаруулалтыг хийнэ.

Үнэлгээнд хараат бус, мэргэжлийн, хөгжлийг хангасан, ил тод, хамтын байх зэрэг зарчмуудыг баримталдаг. Жишээ нь, ил тод зарчмыг хангахын тулд төслийн шалгуур үзүүлэлтийг урьдчилан нээлттэй мэдээлж, материалыг цахим хуудаст нээлттэй байрлуулах боломжийг хангаж өгдөг.

Хамтын байх зарчимд оюутны оролцоог чухалд үзэх төдийгүй, оюутны төлөөллийг үнэлгээний багт оруулдаг. Үнэлгээний үр дүн, сайжруулах талаар хариу зөвлөмжийг өгч ажилладаг байна.

б. Төслийн бүртгэл

Төслийн зар гармагц их сургуулиудын бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүд (цаашид нэгж гэнэ) төсөлд бүртгүүлж болно.

Хэд хэдэн тэнхимүүд нэгдэн төсөлд оролцож болдог. Төсөлд оролцох нэгжийн тоог тухайн сургуулийн оюутны тооноос хамаарч хязгаарлаж өгдөг. Гэхдээ нэг их сургуулиас хамгийн багадаа нэг нэгж оролцох боломжийг олгодог.

Оюутны тоо 1,000-аас их бол хоёр нэгж, оюутны тоо 10,000-аас их бол 10,000 оюутан бүрд нэг нэгж нэмж бүртгүүлэхийг зөвшөөрдөг байна. Бүртгүүлэх нэгж 6 хуудаснаас илүүгүй материалыг бүрдүүлж өгдөг.

Үүнд, төсөлд орох үндэслэл, статистик үзүүлэлтийг өгөгдсөн маягтын дагуу бөглөх бөгөөд ямар нэгж бүртгүүлж буйг мэдэгдэх мэдээллийг оруулахыг байхыг шаарддаг. Үнэлгээний явцад нэмэлт мэдээллийг шаардах боломжтой ажээ.

в. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний 1-р шат нь баримт бичигт үнэлгээ хийн, 2-р шатны шалгаруулалтад орох нэгжийг шалгаруулдаг.

²² Их сургуулийн сургалт гэдэг нь ерөнхий утгаараа их сургуулийн судалгаа (research), сургалт (teaching), нийгмийн үйлчилгээ (service)-г багтааж байдаг. Гэвч энэхүү судалгааны ажилд сургалт гэдгийг ерөнхий утгаар нь бус харин teaching-ээр хязгаарлаж авч үзсэн болно.

²³ Finnish Higher Education Evaluation Council, 2008

²⁴ Parpala & Lindbom-Ylänne, 2007: 357

²⁵ Wild Raaheim & Asko Karjalainen, 2012

²⁶ Finnish Higher Education Evaluation Council

²⁷ Finnish Higher Education Evaluation Council, 2009

Ингэхдээ 1-р шатанд оролцсон бүх нэгжийн мэдээллийг вэб сайтдаа нээлттэй тавьдаг юм. Төслийн үнэлгээний шалгуур нь жил бүр харилцан адилгүй байдаг байна (5 удаагийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг Хавсралтын Хүснэгт 1-т харуулав).

2010-2012 оны үнэлгээний шалгуурын агуулгад дараах зүйлүүд багтаасан.

Үүнд:

(1). Нэгжийн зорилго: Төсөлд оролцох зорилго, үйл явц, оролцох субъектүүдийг товч дурдаж өгнө. Оролцож буй нэгжийн сургалтын зорилго сургуулийн зорилгод гүйцэтгэх үүрэг юу болох?, энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хэрхэн ажиллаж буй?, ингэхдээ нөөцийг хэрхэн зүй зохистой ашиглаж буй? зэргийг тусгаж өгнө.

(2). Хөтөлбөрийн загвар: Сургалтын хөтөлбөрийн бүтцийн талаар бичнэ. Хөтөлбөрүүдийн уялдаа холбоо ямар байгаа?, боловсролын түвшний хөтөлбөр хоорондын уялдаатай эсэх?, сургалт, судалгаа тэнхимийн хувьд уялдаж буй эсэх?, хөтөлбөрүүдэд насан туршийн боловсролын үзэл баримтлал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ туссан эсэх? зэргийг тусган бичнэ.

(3). Сургалтын арга зүй: Сургалтын арга зүйн талаараа бичнэ. Сургалтын арга зүйг хэрхэн сонгож, ашигладаг?, сургалтыг үнэлэхэд үнэлгээний ямар арга ашигладаг, хэрхэн хэрэгждэг?, багшлахуйн арга зүй болон үнэлгээний арга хоорондоо зохицож буй эсэх талаар бичнэ.

(4). Үр дүн: Сургалтын сайжруулах талаар хийгдсэн ажлуудыг чанарын болон тоон үр дүн хэлбэрээр бичнэ. Чанарын үр дүнд оюутны эзэмшсэн мэдлэгийн хэрэглээний ач холбогдлыг илэрхийлнэ.

Жишээ нь сургалтын зорилгыг биелүүлсэн эсэх?, сургалтаар дамжин оюутнуудад мэргэжлийн чиглэлийн мэдлэг олгогдож чадаж буй эсэх?. Харин үр дүнгийн тоон хэмжээс нь сүүлийн 3 жилд хүрсэн үр дүнг харуулах үзүүлэлтийг агуулдаг

(Хавсралтын Хүснэгт 2).

г. Үнэлгээний үе шат

Үнэлгээ баримт бичгийн үнэлгээ ба нэгж

дээрх үнэлгээ²⁸ гэсэн хоёр чиглэлээр хийгддэг. FINHEEC-ээс томилогдсон дөрвөн гадаад мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг баримт бичгийн үнэлгээг хийдэг. Ингэхдээ бүртгүүлсэн нэгжийн нэрийг нууцалдаг тул гадаадын үнэлгээний баг ямар нэгжүүд үнэлгээнд хамрагдаж буй эсэхийг мэдэх боломжгүй юм.

Үнэлгээний баг зохих шалгуурын дагуу үнэлэн, оноог жагсаан, нэгж бүрээр үнэлгээний тайлан гаргаж FINHEEC-д хүлээлгэн өгдөг байна. FINHEEC энэхүү үнэлгээ, тайланд тулгуурлан Хоёр дахь шатны үнэлгээ буюу нэгж дээрх үнэлгээнд хамрагдах нэгжүүдийг сонгож, вэб хуудсандаа байрлуулдаг.

2010-2012 оны хувьд 44 нэгж бүртгүүлснээс 18 нэгж баримт бичгийн шалгуурт тэнцэн 2 дахь шатны үнэлгээнд хамрагдсан байна.

Хоёр дахь шатны үнэлгээний хугацааг FINHEEC-ийн үнэлгээний баг, эхний шатанд шалгарсан нэгжүүдтэй зөвшилцөн тохирдог юм.

Үнэлгээний багт эхний шатны үнэлгээ хийсэн дөрвөн гадаад мэргэжилтэн, дотоодын дөрвөн мэргэжилтэн багтдаг боловч нэг нэгж дээр гурван хүний бүрэлдэхүүнтэй (1 гадаад мэргэжилтэн, 1 дотоод мэргэжилтэн, 1 туслах ажилтан) баг ажилладаг байна. Үнэлгээний баг нэгж дээр ажиллахдаа баримт бичигт тусгагдсан агуулгыг дахин нягтлахын зэрэгцээ, ярилцлага, ажиглалт хийж тухайн нэгжийн сургалтын үйл ажиллагааг үнэлдэг.

Хоёр дахь шатны үнэлгээ дууссаны дараа бүх багууд нэгдсэн хэлэлцүүлэг хийж эцсийн байдлаар төсөлд хамрагдах нэгжүүдийг шалгаруулдаг байна (2012-2014 оны үнэлгээний багийн гишүүдийг Хавсралтын Хүснэгт 3-аас харна уу).

д. Төслийн үр дүн

FINHEEC өнгөрсөн 15 жилийн хугацаанд нийт 3 жилийн үечлэлээр 5 удаа шалгаруулалт зохион байгуулж нийт 87 нэгж шалгаруулж, төслийн санхүүжилт олгожээ (Хүснэгт 2).

Хүснэгт 5-оос харвал Финландын 20 их сургуулийн 17 нь энэхүү төсөлд хамрагдан, бүртгүүлсэн нийт нэгжийн 33 орчим хувь нь шалгарсан байна.

Сургуулийн хэмжээ буюу оюутны тооноос хамааруулан үзвэл өргөдөл өгөх боломжтой нэгжийн тоо 274 хэдий ч бүртгүүлсэн нэгжийн тоо 254 байгаа нь сургуулиуд энэхүү төсөлд хамрагдах сонирхолтой гэдгийг харуулж байна.

²⁸ actual inspection on the spot

<Хүснэгт 2> 1999-2012 онд төсөлд хамрагдсан нэгжийн тоо
(тайлбар 1. CEUE төслийн нэгжийн тоо / 2. Бүртгүүлсэн нэгжийн тоо / 3. Бүртгүүлэх боломжтой нэгжийн тоо)

Сургуулийн нэр/ төслийн он	'99-'00	'01-'03	'04-'06	'07-'09	'10-'12	Бүгд
Хельсинкийн их сургууль	4/7/7	4/8/8	3/8/8	4/9/9	2/5/5	17/37/37
Оулугийн их сургууль	3/3/3	4/4/4	3/3/4	1/5/5	2/3/3	13/18/19
Тамперегийн их сургууль	2/3/3	3/4/4	1/4/4	4/5/5	0/3/3	10/19/19
Түркүгийн их сургууль	2/3/3	2/4/4	1/4/4	3/5/5	1/3/3	9/19/19
Хельсинкийн технологийн их сургууль	2/3/3	2/4/4	1/4/4	2/5/5	1/3/3	8/19/19
Лапперантагийн технологийн их сургууль	0/1/1	1/2/2	1/2/2	0/2/3	1/1/2	3/8/10
Жаваскулагийн их сургууль	0/3/3	0/4/4	2/4/4	0/4/4	1/3/3	3/18/18
Жонсүүгийн их сургууль	1/2/2	1/3/3	1/3/3	0/3/3	0/2/2	3/13/13
Кюпиогийн их сургууль	0/1/1	0/2/2	1/3/3	2/3/3	0/2/2	3/11/11
Хельсинкийн арт, дизайны их сургууль	0/1/1	0/2/2	1/2/2	1/2/2	1/2/2	3/9/9
Сибелюс академи	1/1/1	1/2/2	1/2/2	0/2/2	0/1/2	3/8/9
Хельсинкийн эдийн засгийн сургууль	1/1/1	1/2/2	0/2/2	0/2/2	0/2/2	2/9/9
Лапландын их сургууль	1/1/1	0/2/2	0/1/2	0/2/2	1/2/2	2/8/9
Васагийн их сургууль	0/1/1	0/2/2	1/2/2	1/2/3	0/2/2	2/9/0
Театрегийн их сургууль	0/1/1	1/2/2	1/1/2	0/1/2	0/1/1	2/6/8
Ханкений эдийн засгийн сургууль	1/1/1	0/1/2	1/1/2	1/1/2	0/1/2	2/5/9
Тамперегийн технологийн их сургууль	0/2/2	0/3/3	0/4/4	1/4/4	0/3/3	1/16/6
Финландын уран зургийн Академи	0/0/1	0/0/2	0/1/2	0/1/2	0/1/1	0/3/8
Або академи	0/2/2	0/1/3	0/3/3	0/2/3	0/2/2	0/10/13
Түркүгийн эдийн засгийн сургууль	0/1/1	0/2/2	0/2/2	0/2/2	0/2/2	0/9/9
Бүгд	18/38/39	20/53/59	19/56/61	20/62/68	10/44/47	87/254/274

Эх сурвалж: Arild Raaheim, Asko Karjalainen (2012).

Төсөлд хамрагдсан нэгжүүдийн шинжлэх ухааны чиглэлийг Хүснэгт 3-т харуулав. Шалгарсан нийт нэгжийн 5% нь боловсролын чиглэлийн нэгж байна. 2010-2012 оны төсөлд Оулугийн их сургуулийн Боловсрол судлал, багш боловсролын тэнхим²⁹ шалгарч байсан ба төслийн товч мэдээллийг эх сурвалж³⁰-аас авч болно.

Хүснэгт 3

2010-2012 оны төслийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Шинжлэх ухааны чиглэл	CEUE-д эзлэх хувь
Технологи	18
Хүмүүнлэгийн ухаан	16
Нийгмийн ухаан	16
Байгалийн шинжлэх ухаан	15
Анагаах	11
Арт	10
Бизнес	9
Боловсрол	5
	100
Эх сурвалж: Arild Raaheim, Asko Karjalainen (2012).	

²⁹ Department of Educational Sciences and Teacher Education

³⁰ Osmo Kaupila, 2016

Судалгаагаар энэхүү төсөл нь гадаадын мэргэжилтнүүд төдийгүй, гадаад дотоодын нийгмийн зүгээс сайн үнэлгээг авсан, хэрэгжүүлэгч нэгжүүдэд тодорхой хэмжээний эерэг нөлөө үзүүлсэн гэсэн үр дүн гарчээ. Ялангуяа гадаад хамтын ажиллагаа, багшлахуй-суралцахуйд сайн нөлөө үзүүлсэн гэж дүгнэжээ (Хавсралтын Зураг 1). Нэгжүүд. Төслийн сул тал гэвэл удирдлага, зохион байгуулалтын ажил³¹ гэсэн үр дүн гарчээ³².

4. Судалгааны тэргүүний төвүүдийг дэмжих төсөл (СоЕ)

а. Төслийн тухай

1994 онд Финландын Боловсролын яам судалгааны ажлыг дэмжих зорилгоор судалгааны тэргүүний багийг дэмжихээр СоЕ төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. 1995-1999 онд 17 төсөлд анхны төслийн санхүүжилтийг олгожээ. Судалгааны төслийн шалгаруулалт, үнэлгээг Финландын Академи³³ хариуцан явуулдаг болно.

СоЕ төслийн зорилго нь шинэлэг, бүтээлч, инноваци бүхий судалгааны санаануудыг дэлхийн түвшний судалгаанд хүргэх, үр дүнг амьдралд нэвтрүүлэх явдал юм. Тийм учраас энэхүү төсөл нэг удаагийн төслөөр дуусах бус тасралтгүй, үргэлжилсэн байдлаар хэрэгждэг онцлогтой³⁴. Төслөөр дамжуулан их сургууль, судалгааны байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилготой юм. Энэхүү төсөл нь нийгэмтэй холбоотой ажиллахыг чухалчилдаг бөгөөд судалгааны хөгжил, нийгмийн хэрэгцээ, хүлээлттэй нийцсэн байх шаардлагыг тавьдаг³⁵. Төслийн санхүүжилтийг судлаачдыг бэлтгэх, тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэхэд зарцуулдаг³⁶.

Төслийг санхүүжүүлэхдээ цэвэр шинжлэх ухааны судалгаа ба хэрэглээний судалгааны чиглэлийг харилцан тэгш санхүүжүүлэх төдийгүй хоёр чиглэлийн хамтарсан судалгааг дэмждэг байна. Судалгааны төслийн санхүүжилтийг анх 5 жилээр олгож эхэлсэн ч судалгааны тасралтгүй чанарыг нэмэгдүүлэх үүднээс 2000 оноос эхлэн 6 жилээр олгож эхэлжээ. Төсөлд их сургууль, судалгааны төв төдийгүй бизнесийн байгууллага зэрэг өргөн хүрээний субъектүүд оролцож болдог.

Ийнхүү оролцооны хүрээг өргөтгөснөөр Финландын судалгааны чадавхыг дээшлүүлэх зорилготой байдаг. Судалгааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Финландын Академиас гадна судалгааны сангууд, хувийн бизнесийн байгууллагууд хамтран ажилладаг³⁷. Энэхүү төсөл зөвхөн байгалийн шинжлэх ухааны төслийг дэмжих бус, нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн судалгаануудыг дэмждэг.

б. Төслийн бүртгэл

Финландын Академиас гаргасан загварын дагуу СоЕ төсөлд хамрагдах хүсэлтээ гаргана. 6 жилийн судалгааны зорилго, үйл ажиллагааг төлөвлөн, эхний 3 жилийн үйл ажиллагаагаа түлхүү бичдэг. Судалгааны төлөвлөгөөний хэмжээ нь 20 хуудаснаас ихгүй байна. Төлөвлөгөөнд дараах агуулгуудыг заавал тусгасан байна. Үүнд:

- Судалгааны тухай, судалгааны сэдэв, судлагдсан байдал
- Судалгааны зорилго, судалгааны шинэлэг тал, судалгаанаас хүлээж буй үр дүн
- Судалгааг хэрэгжүүлэх нөөцийн чадавх
- Судалгааны багийн сайн, сул талууд
- Судалгааны шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр

в. Үнэлгээ

Төслийн шалгаруулалтыг Финландын Академийн зөвлөл³⁸ хийх бөгөөд зөвлөлд мэргэжлийн судлаачдыг сонгодог ажээ. Энэ зөвлөл нь төслийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах бөгөөд хамгийн чухал үзүүлэлт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх гэсэн үзүүлэлт байдаг. Шалгаруулалт 18 сарын хугацаанд хоёр үе шаттай явагдана. Шалгаруулалтыг гадаадын мэргэжилтнүүд хийдэг байна³⁹.

Үнэлгээнд судалгаа олон улсад өрсөлдөж чадах эсэх, судалгааны ажлын өртөг, судалгааны нийгэм, эдийн засгийн үр ашиг, нөлөө зэргийг харгалзан үздэг⁴⁰. Үнэлгээнд тухайн судалгаа амжилтгүй болох магадлал, эрсдэл зэргийг тооцсон байдаг. Судалгааны санхүүжилтийн субъект нь хувь хүн бус баг байдаг тул багийн олон улсад өрсөлдөх чадавхыг бас харгалзан үздэг.

³¹ administrative workload

³² Arild Raaheim, Asko Karjalainen, 2012

³³ Academy of Finland

³⁴ Academy of Finland, 2009; Finnish Ministry of Education, 2004

³⁵ Kanninen & Lemola, 2006

³⁶ Academy of Finland, 1997

³⁷ Hjelt, 2009

³⁸ Board of Academy

³⁹ Academy of Finland, 1997; Hjelt, 2009

⁴⁰ Hjelt, 2009

г. Шалгаруулалт

СоЕ төслийг шалгаруулахдаа дараах дөрвөн чиглэлээр шалгаруулдаг Үүнд, 1. тухайн чиглэлдээ олон улсад өрсөлдөж чадах судалгааны үр дүн гаргах судалгааны баг, 2. олон улсын түвшний судалгааны өндөр чадавхтай, тодорхой судалгаа сэдэв, зорилго бүхий судалгааны баг, 3. шилдэг судлаачдаас бүрдсэн судалгааны баг, 4. ижил төрлийн судалгаа хийдэг судлаач, судалгааны багийн нэгдэл гэсэн чиглэл багтдаг⁴¹.

Шалгаруулалт хэд хэдэн шатаар явах бөгөөд хамгийн эхэнд судалгааны ерөнхий танилцуулгад урьдчилсан үнэлгээ хийж, үүнээс шалгарсан багуудаас судалгааны нарийвчилсан төлөвлөгөөг авч дахин үнэлэх бөгөөд гадаадын мэргэжилтнүүд үүнд оролцдог. Шалгаруулах зөвлөлд шинжлэх ухаан, технологи, санхүүгийн мэргэжилтэн, Боловсролын яамны ажилтан, шалгаруулалтад оролцож байсан байгууллагын төлөөлөл зэрэг багтсан байдаг. Харин тухайн онд шалгаруулалтад орж буй байгууллагуудаас төлөөлөл оролцуулдаггүй. Хэрэв үйлдвэрлэлтэй холбоотой судалгааны төсөл байвал аж үйлдвэр, эдийн засгийн мэргэжилтэн багтсан байдаг⁴².

Үндсэн шалгаруулалт хоёр үе шатаар явагддаг. Эхний шат нь цахим бүртгэлээр ирүүлсэн баримт бичигт үнэлгээ хийх бөгөөд бүртгүүлэгч 20 хуудсанд багтаан судалгааны төлөвлөгөөг ирүүлдэг. Энэ шатанд шалгарсан бүртгүүлэгч дараагийн шатны шалгаруулалтад оролцдог. Дараагийн шатны шалгаруулалтад оролцогчид өгөгдсөн загварын дагуу материал бүрдүүлж өгдөг.

д. Судалгааны санхүүжилт

Энэхүү төсөлд шалгарсан төслийг 6 жилийн хугацаатай санхүүжүүлэх бөгөөд 3 жилийн үечлэлээр үнэлгээ хийж, үргэлжлүүлэх эсэхийг шийддэг. Төсөл судалгааг 100 хувь санхүүжүүлдэггүй, санхүүжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэгч байгууллага зөвшилцөн санхүүжилтийн хэмжээг тогтоодог⁴³. Тиймээс шалгарсан төслийн санхүүжилт харилцан адилгүй байдаг. Санхүүжилтийн зарцуулалт нь судалгааг хэрэгжүүлэхэд гарч буй бүхий л зардалд хамаардаг⁴⁴.

е. Төслийн үр дүн

Төсөл хэрэгжиж эхэлсэн 1995 оноос хойш 2019 он хүртэл 7 удаа шалгаруулалт явагдаж нийт

129 судалгааны төсөл шалгарч, санхүүжилт авсан байна (Хүснэгт 4). 2012-2017 онд шалгарсан 15 төслийн чиглэлүүдийг Хавсралтын Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4

Шалгарсан СоЕ төслийн тоо

Он	Төслийн тоо
1995–1999	17
2000–2005	26
2002–2007	16
2006–2011	23
2008–2013	18
2012–2017	14
2014–2019	15

Эх сурвалж: Academy of Finland, 2016. From: <http://www.aka.fi/en/research-and-science-policy/centres-of-excellence/completed-coe-programmes/>

СоЕ төслийн үр дүнгийн талаар судалгааны тайлангуудад дурдсан байна. Судалгааны төслийн үр дүн нь нийгмийн хүлээлтэд нийцэж буй хэмээн үнэлэгдэж байна⁴⁵. СоЕ төсөл анхнаасаа өндөр түвшний судалгаа нийгмээс тусгаар бус, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах ёстойг чухалчилдаг бөгөөд өдгөө ч үргэлжилсээр байна. Нөгөө талаар төслийн үр дүн улсын түвшний судалгаа, инновацийн тогтолцоонд маш их хувь нэмэр оруулж байна⁴⁶.

Шалгаруулалтад судалгааны байгууллагуудын онцлогийг харгалзан үзэх үүднээс СоЕ төсөл доороос дээш⁴⁷ чиглэлтэй явж ирсэн нь санхүүжилтийн ийм чиглэлийг суурьшуулахад хувь нэмрээ оруулсан хэмээн үздэг. Мөн энэхүү төсөл дээд боловсролын байгууллагын үнэлгээ, санхүүжилтийн шинэ загварыг боловсруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн юм. Төслийн дүнд судлаачдын тоо өсөж, 2000-2005, 2002-2007 онуудад дунджаар судлаачдын тоо 43%-аар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү тоог их сургуулийн багш, судлаач, докторантаар ангилан авч үзвэл докторант судлаачдын тоо хамгийн их нэмэгдсэн байна. Их сургуулийн багшийн оролцоог авч үзвэл их сургуулийн нийт багш нарын 4.5 хувь нь тус төсөлд оролцож байна. Энэхүү төслөөр нэг судалгааны ажлыг 6 жилээс дээш хугацаанд санхүүжүүлдэг тул судалгааны сэдвээр тогтож, судалгаа эхлүүлэх суурь болдгийг баталсан.

⁴¹ Academy of Finland, 1997

⁴² Kanninen & Lemola, 2006

⁴³ Academy of Finland, 2009; Hjelt, 2009

⁴⁴ Academy of Finland, 2001

⁴⁵ Academy of Finland, 2009

⁴⁶ Academy of Finland, 2009; Finnish Ministry of Education, 2004

⁴⁷ bottom-up

Төслийн хугацаанд судалгааны багууд судалгааны агуулга, арга зүйдээ өөрчлөлт хийх оролдлогууд хийж, судалгааны үр дүнг ашиглах, түгээх тал дээр үр дүнтэй ажиллаж байна. Мөн урт хугацааны судалгаа нь эрсдэл өндөртэй судалгаа хийх боломжийг олгож байдаг⁴⁸.

5. Онцлогууд

а. Үнэлгээний байгууллагын бие даасан, тогтвортой байдал.

Дээд боловсролын байгууллагын төслийн үнэлгээ хийх байгууллагын бие даасан байдлыг бүрэн хангаж чаджээ. Хэдийгээр Боловсролын яамны харъя байгууллага хэдий ч төслийн үнэлгээ хийхдээ бие даасан байдлыг бүрэн хангаж чадсан төдийгүй үнэлгээний багийг мэргэжлийн түвшинд бүрдүүлж чаддаг байна.

б. Шалгаруулалтын бэлтгэл, үйл явц хялбар

Шалгаруулалтад оролцох бэлтгэл, бүрдүүлэх баримт бичгийг хялбаршуулжээ. CEUE төслийн хувьд шалгаруулалтын эхний шатанд бүхий л материалыг бэлдэх шаардлагагүй, зөвхөн өгөгдсөн маягтын дагуу 6 хуудсанд багтаан материал бэлтгэх бөгөөд бүрдүүлэг бүрдүүлсэн материалыг бүгдийг шалгах хэдий ч харьцангуй цөөн материал бүрдүүлэхээр зохицуулжээ. Энэ нь шалгаруулалтын ажилд цаг хугацаа, хүн хүчийг үр дүнгүй зарахгүй байх боломжийг олгодог байна. СоЕ төсөл мөн адил бүрдүүлэх материалын тоог багасгаж, судалгааны онцлогоос хамаарч шаардлагатай нөхцөлд нэмэлт материалуудыг шаарддаг байна.

в. Үр дүнд суурилсан үнэлгээ, үнэлгээний шилэн чанар

Үнэлгээний үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлж, үнэлгээг дээд боловсролын байгууллагын хөгжлийн нэг түлхүүр болгож чадсан байна. Энэ нь ирүүлсэн төсөл бүрт үнэлгээ хийж, шалгарсан эсэхээс үл хамааран хариу зөвлөмжийг өгдөгөөс харагдаж байна. Мөн үр дүнг нээлттэй тавьснаар өөрийн сургуулийг бусад сургуулиудтай харьцуулан хөгжих боломжийг олгодог ажээ.

г. Олон улсын шалгуурт нийцсэн шалгуур
Дээрх төслүүд нээлттэй өрсөлдөөнт шалгаруулалтад суурилдаг. Үнэлгээ маш тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу явагдаж, гадаадын мэргэжилтнүүд үнэлгээний багт ажилладаг байна.

д. Тасралтгүй санхүүжилт

Дараагийн нэг онцлог бол санхүүжилтийг

нэг удаа олгоод зогсохгүй тасралтгүй байдлыг хангах үүднээс урт хугацааны санхүүжилт олгодог явдал юм. CEUE төсөл 3 жил, СоЕ төсөл 6 жилийн хугацаатай санхүүжилт авдаг ч хугацаа дуусвал тодорхой үнэлгээ хийсний дараагаар үргэлжлүүлэн санхүүжилт олгох боломжтой байдаг

е. Судлаачдыг бэлтгэх

Финландын дээд боловсролын байгууллагыг дэмжих төслийг нэг онцлог нь шинэ судлаачдыг бэлтгэх, чадавхжуулахад анхаардаг оршино. Үүний тулд тусгай төсөл хэрэгжүүлэхгүй, хэрэгжиж буй бүхий л төслүүд судлаачдыг бэлтгэх, чадавхжуулахад маш их анхаарч ажилладаг байна.

Ашигласан материал

Academy of Finland (1997). National strategy for centres of excellence in research. Academy of Finland. From: <http://www.aka.fi/globalassets/awanhat/documents/tiedostot/julkaisut/excellence.pdf>

Academy of Finland (2009). Academy of finland in brief. Academy of Finland.

Arild Raaheim & Asko Karjalainen (2012).

Centres of excellence in university education Finland 1999–2012. From [file:///C:/Users/Pcc/Downloads/KKA_1312%20\(1\).pdf](file:///C:/Users/Pcc/Downloads/KKA_1312%20(1).pdf)

Finnish Higher Education Evaluation Council (2009). Centres of Excellence in Finnish University Education 2010-2012 from: https://karvi.fi/app/uploads/2015/01/KKA_0309.pdf

Korea Educational Development Institute (2010). A Study on Enhancement of Public Funding of Higher Education. 연구보고 RR 2010 – 15. In Korean.

Hjelt, M. et al. (2009). Impact evaluation of Finnish programmes for centres of excellence in research 2000-2005 and 2002-2007. Publication of the Academy of Finland 2/09. From: http://www.aka.fi/globalassets/awanhat/documents/tiedostot/julkaisut/2_09-coe-in-research.pdf

Osma Kauppila (2016). Excellence in Teaching: Centres of Excellence in Finnish University Education 2010–2012. From <http://www.tojqih.net/journals/tojqih/articles/v03i01/v03i01-02.pdf>

ХАВСРАЛТ

<Хүснэгт 1> Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

1999–2000 content areas:
<ol style="list-style-type: none">1. Objects and contents of the education2. Delivery of the education3. Evaluation of the education4. Future scenarios and development plans
2001–2003 content areas:
<ol style="list-style-type: none">1. Planning of the education, objectives and contents of the education2. Delivery of the education3. Evaluation and development of the education4. Future scenarios and development plans.
2004–2006 content areas:
<ol style="list-style-type: none">1. Mission, objective and contents of the education2. Delivery of the education3. Evaluation of the education.
2007–2009 content areas:
<ol style="list-style-type: none">1. How does the unit define its educational mission at the university and at the national level? How does the work community support this mission and how can its impact be seen in teaching and instruction practices?2. How have the profound learning and active role of the students been promoted? How has students' growth towards academic expertise been supported?3. What has the unit done to establish good learning environments?4. How is teaching connected to the active research of the unit?5. How does the unit interact with the surrounding society?6. How have the perspectives of working life and scientific quality been assimilated in education?7. How does the unit evaluate its quality and what are the evaluation results?8. How are degree reform, curriculum development and pedagogical development interlinked?
2010–2012 content areas:
<ol style="list-style-type: none">1. Mission of the unit. A brief description of the unit and the way in which the application was compiled and who participated in the work.2. Programme and course design. A description of the curriculum design.3. Delivery of education. A description of the teaching methods used and how they are chosen and applied; also, a description of what methods are used to assess learning and on what grounds.4. Outputs. A description of the qualitative and quantitative outputs of the unit.5. Continual development. A description of the procedures used to identify critical points in education and in the curriculum and how the problems are solved.
Эх сурвалж: Finnish Higher Education Evaluation Council (2009).

<Хүснэгт 2> Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур	Үзүүлэлт
Students	Admitted new students
	Registered students, total
	Lower (BA) degrees awarded
	Higher (MA) degrees awarded
	Median duration of study in years
	Credits completed by degree students in the unit
Postgraduate students	Registered students, total
	Licentiates awarded
	Doctorates awarded
Minor subject students (students from other units)	Students, total
	Credits completed by minor subject students
Other education provided by the unit	Credits other than above completed in the unit
Structure of teaching, research and other personnel 2005 2006	Teaching and research personnel
	Professors
	Other teaching staff
	Other personnel
	Docents/Adjunct professors
	Amount of teaching given by adjunct professors (docents)
Internationalisation	Foreign degree students
	Foreign postgraduate students
	Foreign personnel
Funding	Appropriation for operational expenditure (1000 e)
	External funding (1000 e)
Эх сурвалж: Finnish Higher Education Evaluation Council (2009).	

<Хүснэгт 3> 2010-2012 оны төслийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн

The international experts:

Vice Rector Birute Klaas, University of Tartu, Estonia

Professor Arild Raaheim, University of Bergen, Norway

Deputy School Secretary Helen Uglow, London Business School, UK

Head of Unit Stefan Bienefeld, German Rectors' Conference, Germany

The Finnish experts:

Student Suvi Eriksson, University of Oulu


Student Jonas Heikkilä, Åbo Akademi University

Professor Emeritus Juhani Jussila

Regional Development Director Vesa Taatila, Laurea Polytechnics

Эх сурвалж: Finnish Higher Education Evaluation Council (2009)

<Зураг 1> Effects of having a CEUE status (-3 is most negative and +3 is most positive)



<Хүснэгт 4> 2012-2017 онд шалгарсан төслүүдийн чиглэл

Cancer Genetics Research
The History of a Society: Rethinking Finland 1400-2000
Nuclear and Accelerator-based Physics
Computational Inference Research
Russian Studies - Choices of Russian Modernisation
Molecular Systems Immunology and Physiology Research
Inverse Problems Research
Atomic Layer Deposition (ALD)
The Philosophy of the Social Sciences
Biological Interactions Research
Metapopulation Research
Low Temperature Quantum Phenomena and Devices
Cell-Extracellular Matrix Research
Intersubjectivity in Interaction
Computational Nanoscience

Эх сурвалж: Academy of Finland, 2016. From: <http://www.aka.fi/en/research-and-science-policy/centres-of-excellence/current-coe-programmes/centres-of-excellence-in-research-20142019/>

Орчуулсан: Г.Өлзийсайхан, доктор, МУБИС
Г.Дэлгэрсайхан, Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Булган